



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТЭД 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТАЙЛАН**

2025.07.07

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт”-ийн дагуу 5 хэсгийн нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг төрийн байгууллага www.shilen.gov.mn сайтад тайлагнаж, хэрэгжилтэд Харилцаа холбоо, цахим хөгжлийн яам хяналт тавьж ажиллаж байна.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу иргэдэд Зам, тээврийн яам болон салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ил тод, шуурхай хүргэх, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хоёр. Танилцуулга:

2025 оны эхний хагас жилийн байдлаар Зам, тээврийн яамны нээлттэй мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлгээг харуулбал. Үүнд:

Хүснэгт 1.

Хэсэг	Арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/					Хугацаа болоогүй	Хамааралгүй	ХШҮ /хувь/
		100	70	50	30	0			
1	10	2	2	3	1	2	-	-	52.0
2	6	4	-	1	-	1	-	-	75.0
3	15	12	1	-	1	-	1	-	92.9
4	2	2	-	-	-	-	-	-	100.0
5	13	7	1	1	-	-	1	3	91.1
Нийт	46	27	4	5	2	3	2	3	80.2

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд “0-30” хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээг дурдвал:



Хүснэгт 2.

№	Д/д	Мэдээлэх арга хэмжээ	Үнэлгээ	Тайлбар
1	8.2.3	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	0	БТГ мэдээллийг шинэчлэн байршуулах
2	8.2.3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	30	ХШҮДАГ мэдээллийг шинэчлэн байршуулах
3	8.2.3	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	0	ХШҮДАГ мэдээллийг шинэчлэн байршуулах
4	8.3.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	0	ТЗУГ мэдээллийг шинэчлэн байршуулах
5	8.4.11	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	30	Ажлын хэсэг мэдээллийг шинэчлэн байршуулах

Зам, тээврийн салбарын харьяа 10 байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнаж ажилласан. Нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлэв:

/Хүснэгт 3/

№	Харьяа байгууллага	Арга хэмжээний тоо	Үнэлэгдсэн арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/	Хамааралгүй арга хэмжээ
1	ИНЕГ	46	40	94.2	6
2	НТОЗШША	46	12	85.3	34
3	“МИАТ” ТӨХК	46	34	92.0	12
4	ХХНОБ ТӨХХК	46	28	86.8	18
5	ДЗ	46	28	82.1	18
6	“МТЗ” ТӨХК	46	39	77.2	7
7	“ТТЗ” ХХК	46	37	77.3	9
8	“УБТЗ” ХНН	46	25	83.6	21
9	“АТҮТ” ТӨҮГ	46	34	85.8	12
10	“ЗТХТ” ТӨҮГ	46	22	70.8	14

Гурав. Үнэлэлт, дүгнэлт:

Зам, тээврийн яамны нээлттэй мэдээллийн ил тод, байдлын хэрэгжилтэд 2025 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнг үзүүлсэн байна.



3.1. Зам, тээврийн яамны Нээлттэй мэдээллийн ил тод, байдлын дундаж үнэлгээ 80.2 хувь байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,9 функтээр буурсан байна.

3.2. Зам, тээврийн салбарын хэмжээнд харьяа 10 байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж ажилладаг ба хэрэгжилтийн дундаж үнэлгээг байгууллагын үйл ажиллагааг дүгнэх нэг үзүүлэлт болж байна.

3.3. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу яамны цахим хуудсанд мэдээг тайлагнах цонх шинээр нээж, мэдээллийг хариуцсан мэргэжилтэнг цохон томилон, мэдээллийн ил тод байдалд байнгын хяналт тавьж ажилласан нь сайшаалтай байна.

Дөрөв. Санал, зөвлөмж:

4.1. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээ хийх журам"-ын шалгуур үзүүлэлтийн дагуу ил тод байдлын хэрэгжилтэд үнэлгээ хийхийг ХШҮДАГ-т;

4.2. Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг БТГ-т;

4.3. Яамны цахим хуудсанд байршсан хуучирч цаг хугацааны хувьд үнэ цэнэ алдсан мэдээллүүдийг устгах, цахим мэдээллийн самбарт мэдээллийг шинэчилж ажиллахыг ТЗУГ, БТГ-т;

4.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг яамны цахим самбар, мэдээллийн самбар болон бусад аргаар олон нийтэд түгээх, төрийн үйлчилгээг ил тод, хүнд сургалтгүй байлгахад анхаарч, мэдээллийн баяжуулалтыг тухай бүр хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг нийт албан хаагчид анхаарах;

4.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг цаг хугацаа, тоо баримттай, холбогдох цахим холбоосын хамт тайлагнаж байхыг яам болон харьяа байгууллагын албан хаагчдад тус тус зөвлөж байна.

ХШҮДАГ